

Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг

Анх 1955 онд Зүүн хорооны 30 ортой больницыг 26 орон тоотойгоор нээн ажиллуулсан. 1959 оноос дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд, нүд зэрэг нарийн мэргэжлийн кабинетуудыг 12 их эмч, 4 баг эмч, 11 сувилагч, нийт 45 орон тоотойгоор амбулаторийн үйлчилгээ явуулж байгаад хүүхдийн хэсгүүд райончлогдоход 1966 онд 5 хүүхдийн хэсэгтэй болж өргөжсөн.

1967 оны сүүлчээр Улаан хуран, Амгалан, Консулд хүүхдийн хэсгүүд шинээр байгуулж, 1978 онд нарийн мэргэжлийн диспансерууд райончлогдон арьс өнгө, сүрьеэг ийн диспансерууд шилжин ирж ажиллаж эхэлжээ.

1979 онд амбулаторийн шинэ барилга ашиглалт-анд орж 1986 оноос 155 ортой нэгдсэн эмнэлэгтэй болж 1 ээлжид 300 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай амбулатори, 120 ортой хүүхдийн больниц болж салгаж гарсан байна.

Ийнхүү тус больниц нь 155 ортой, эмчилгээний 2 тасаг, 10 гаруй туслах кабинетуудтай 50 их эмч, 80 гаруй дунд мэргэжилтэн нийтдээ 205 ажилчин албан хаагчтай, дотор мэс засал, чих хамар хоолой, мэдрэл, зүрх судас, нүд шүд, рентген, физик эмчилгээ, клиник лаборатори, зүү эмчилгээ, зэрэг 11 төрлийн нарийн мэргэжлээр үйлчилгээ явуулж ирсэн байна. 1983-1994 он хүртэл хүүхдийн эмнэлгийн даргаар Адъяа, 1994-1997 оны 7 сар хүртэл Осоржамаа нар ажиллаж байв.

1995 оноос төрөлт багасаж хүүхдийн хэвтэлт буурсантай холбоотой хүүхдийн эмнэлгүүд цалингаа тавьж чадахгүй болход хүрч Тус эмнэлгийн 3 давхарын нэг жигүүрийг "Зочид буудал болгон түрээсэлж, мөн "Баянзүрх дүүргийн засаг дарга захирамжаар 4 хорооны насанд хүрэгсдийг авч эмчлэх шийдвэр гарч насанд хүрэгсэдийг эмчилж эхэлсэн.

1941 онд Зөвлөлтийн элчин сайдын яамны дэргэд Амбулатори нэртэйгээр нээгдэж ажиллажээ, 1945 оноос эхлэн 60 ортой эмэгтэйчүүд, арьс өнгөний тасаг, Зөвлөлтийн эмч Зимнаякова Расшесва, Лапатка зэрэг мэргэжилтэн эмч нар ажиллаж байжээ.

1946 оны 8 дугаар сарын 10- анд хотынх эмнэлгийн хэлтсийн шийдвэрээр арьс өнгөний өвчтөнд Ганд ангийн нэгдсэн больниц од шилжүүлж эмчлэн 40 ортойгоор 1946 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр хүртэл 1947 оны 1 дүгээр сарын 1-нээ эхлэн Зөвлөлтийн мэргэжилтний 10 ортой 30 шахам орон тоотой больниц амбулаторийн хамтаар ажиллаж ерөнхий эмч нь Зөвлөлтийн мэргэжилтэн Адонисова, Усава, Вальшнова зэрэг эмч нар нь 1952-1954 оны үед мэргэжилтний больницын нэрээр ажиллаж байлаа. Үүний дараа мэргэжилтний больниц нь сайд нарын эмнэлэгтэй нийлснээс хойш уг эмнэлэг нь Элэгний шарлах өвчний больниц болон өөрчлөгдсөн. Ингээд 1955 оны үед Улиастайн хорооны больниц, дараа нь зүүн хороодын больниц нэртэй ажиллаж байв.

Энэ үед дарга нь Нансалмаа, 26 ортой, 30 ортой больниц, амбулаторийн хамт ажиллаж байсан байна.

1956-1957 оны үед шарын больниц, 1963 оны үед 40 ортой 2 эмчтэй, 1 сувилагчтай байв.

1959-1962 онд дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд гэрэл, шүд зэрэг тасгуудтай 12 их эмч 4 бага эмч, 11 сувилагч 1 комендант зэрэг 45 орон тоотой нарийн мэргэжлийн амбулатори болон ажилласан. Дарга нь Цэдэн-Иш байсан.

1966 оны 1 дүгээр сараас 5 хэсэгтэй бага эмчийн салбар болж ажилласан. 1967 оны 0 4 дүгээр сарын 15-нас эхлэн хүүхдийн эмнэлгийн ажиллагааг райончилсонтой холбогдуулан хүүхдийн 7 эмч нэмэгдсэнээс хүүхдийн хэсгийн эмч 12 болж бүгд 58 орон тоотой ажиллаж байсан. Энэ үед амбулаторийн дарга эмч Номин далай, хүүхдийн зөвлөх эмч Бадам ханд 1975 оноос ерөнхий эмчээр Д.Ухнаа, Долгормаа, 1978 оноос Ц.Мядагмаа, 1979 оноос Ш.Долгормаа, намын үүрийн даргаар С.Цэрэв. Долгор-жид, Д.Бямбаа нар ажиллаж байв.

1978 оноос сүрьеэ, арьс өнгөний диспансери нэгдсэн төвөөс салж ирсэн байна.

1979 оны 2 дугаар сараас амбулатори шинэ байранд орсон. 1980 оноос зүрх судасны кабинет, 1981 оноос биеийн тамир, зүү эмчилгээний кабинет, Шар хадны хүүхдийн 9-р цэг, Улиастайн хүүхдийн\ийн 7-р цэгт, Сансарын дотрын хэсэг анх байгуулагдаж ажиллаж эхэлсэн.

1979 оноос байгууллагын хүндэт дэвтэртэй болжээ.

1982 оноос их эмч 71, бага эмч 18,сувилагч 62, бусад ажилчид 45 нийтдээ 205 ажилтантай байжээ.

"Баянзүрх нэгдсэн эмнэлэг" ХХК

Монгол улсын Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор нийгмийн салбарын хувьчлалын туршилт хэрэгжүүлэх байгууллагын жагсаалтад эрүүл мэндийн салбарыг төлөөлүүлэн Нийслэлийн Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг насанд хүрэгчдийн нэгдсэн эмнэлэг, хүүхдийн нэгдсэн эмнэлгийн оруулж баталж хувьчлалын ажлын эхлэл тавигдсан.

Засгийн Газрын 1997 оны 160 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр 1997 оны 04 дүгээр сарын 29-өд ЭМНХ-ын сайд, Төрийн өмчийн хорооны даргын Эрүүл мэндийн салбарын хувьчлалын талаар авах зарим арга хэмжээний тухай хамтарсан А/175/76 дугаар тушаал гарч төсөл шалгаруулах ажил явагдсан байна.

Ийнхүү тендерийн төслийг сонгон шалгаруулах комисс 1997 оны 06 дугаар сарын18-анд Б.Даг-Яндаг ахлагчтай багийг шалгаруулсан тухай мэдээллийг 6 дугаар сарын 19-энд гаргаснаар менежментийн гэрээ байгуулах хэлцэл явагдан 7 дугаар сарын 1-энд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Баянзүрх дүүргийн Засаг дарга , эмнэлгийн удирдлагын багийн ахлагч Б.Даш-Яндаг нар гэрээнд гарын үсэг зурж Баянзүрх эмнэлэг үйл ажиллагаагаа эхэлсэн Тус эмнэлэг нь 1997 оноос менежментийн гэрээгээр ажиллаж байгаад 2004 оны 10 дугаар сарын 8-ний өдрийн Нийслэлийн Өмч хувьчлалын комиссын 98 тоот тогтоолоор хувьчлагдсан. НЗД-ын 2004 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 566 тоот захирамжаар Баянзүрх эмнэлгийн Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, НӨХК-ын 2005 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 109 тоот тогтоолоор Б.Даш-Яндаг ахлагчтай багт "Баянзүрх эмнэлгийн өмчлөгчийн эрхийг шилжүүлж, тус эмнэлэг "Баянзүрх эмнэлэг"ХХК болон 2006 оны 3 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Баянзүрх эмнэлэг нь 2004 онд аймаг, дүүргийн чиглэлээр явуулсан сургалт анд эмнэлгийн удирдлага,санхүүгийн ажилтнуудыг 2 удаа хамруулсан.

Хүний нөөцийн чадавх: 2008 оны байдлаар141 ажиллагсад ажиллаж байгаагаас25 их эмч,4 удирдах ажилтан,53 эмнэлгийн дунд мэргэжилтэн, 23 асрагч үйлчлэгч 21 бусад ажиллагсадтай байна.